

Түүхийн улсын олимпиадын II давааны 9-р ангийн сурагчийн сорил -2024.

1. Цагаан агуйн чулуун зэвсгийн суурин хаана байдаг вэ? (1 оноо)
 - a. Хэнтийн нуруу
 - b. Хангайн нуруу
 - c. Монгол Алтайн нуруу
 - d. Говь Алтайн нуруу
 - e. Саяны нуруу
2. Хойд Цэнхэрийн агуйн зургийн өвөрмөц дүрслэл аль вэ? (1 оноо)
 - a. Бодит байдлаас томоор дүрслэн зурсан
 - b. Монголд нутаглаж байгаагүй амьтдыг зурсан
 - c. Тухайн амьтныг төлөөлүүлж толбо тавьсан
 - d. Хурц үзүүртэй зүйлээр чадмаг сийлсэн
 - e. Ховордсон амьтдыг өсөж үржихийг бэлгэдэж зурсан
3. Нүүдлийн мал аж ахуйн үүсэлд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн мал аль вэ? (1 оноо)
 - a. Тэмээ
 - b. Үхэр (тэрэг)
 - c. Хонь, ямаа
 - d. Адуу
 - e. Сарлаг
4. Монголд нүүдлийн мал аж ахуй үүссэний гол ач холбогдол юу вэ? (1 оноо)
 - a. Малын тоног хэрэгсэл буй болсон
 - b. Төр улс үүсэх урьдач нөхцөл бүрдсэн
 - c. Хүн амын тоо эрс өссөн
 - d. Морин цэрэг үүссэн
 - e. Чинээлэг сурвалжит хүмүүс буй болсон
5. Хүннү улсыг Хятадын Хан улсаар хүлээн зөвшөөрүүлж, гэрээ байгуулсан шаньюй аль вэ? (1 оноо)
 - a. Түмэн шаньюй
 - b. Модунь шаньюй
 - c. Лаошан шаньюй
 - d. Зүнчэн шаньюй
6. Сурвалжийн мэдээг уншиж асуултад товч хариулж бичнэ үү.
“Өмнө зүгт хил хязгаарт орж түйвээгээд, умард этгээдээс динлин нарын довтлох довтолгооныг зогсоож, зүүн талд фүюй нарыг няцааж, баруун тийш усунь нарыг бутцохиж . . . дорноос өрнө хүртэл 14 мянган бээр газрыг . . . эзлэн захирсан” (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)
 - a. Энэ мэдээ ямар сурвалжид байдаг вэ?
 - b. Энэ мэдээнд ямар улсын тухай өгүүлж байна вэ?
 - c. Энэ мэдээ ямар хааны үед холбогдох вэ?
7. Дараах бичвэрийг нөхөж бичнэ үү.
V зууны эхээр хаан сууж байсан -ий үед улс ихэд хүчирхэгжиж байв. Алтайн-ийн бослогоор тус улс мөхөв. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)
8. 1889 онд Орхоны хөндийгөөс илрүүлэн олж, 1893 онд тайлж уншсан эртний нүүдэлчдийн бичиг үсэг аль вэ? (1 оноо)
 - a. Уйгур бичиг
 - b. Монгол бичиг
 - c. Руни бичиг
 - d. Брахми бичиг
 - e. Согд бичиг
9. Дараах өгүүлбэрээс зөв 2 хариултыг сонгоно уу. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
 - a. Хөлөн, Буйр нуураар төвлөрсөн жужанчуудыг анх Гучин татар гэж Түрэг, Уйгурын түүхэнд тэмдэглэсэн.
 - b. Нутагтаа үлдсэн жужанчуудаас хожим Найман, Хэрэйд, Мэргид аймаг, улсууд гарсан.

- c. Эргүнэ гүний монголчуудыг хожим 9 татар гэж нэрлэсэн.
d. Жужанчууд Түрэгийн довтолгоонд шахагдан нутгийн баруун талаар нутагласан.
10. Чингис хааны мэндэлсэн Дэлүүн болдог хаана байдаг вэ? (1 оноо)
a. Хэнтий аймгийн Дадал сумын төвийн зүүн талд
b. Хэнтий аймгийн Дадал сумын төвийн баруун талд
c. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын төвд
d. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын хойд талд
11. Их Монгол улсын хөрш улсуудыг гүйцээж бичнэ үү. (Зөв хариулт бүр 0.5 оноо, нийт 2 оноо)
a. Баруун талд (1218 он хүртэл).....b. Баруун талд (1218 оноос хойш).....
c. Зүүн өмнөд талд d. Урд талд
12. Ил хаант улсын Газан хаан аль шашныг төрийн шашин болгосон бэ? (1 оноо)
a. Бурхны шашин
b. Бөөгийн шашин
c. Лалын шашин
d. Үнэн алдартны шашин
13. Цагадайн улсад зоосон мөнгө гүйлгээнд оруулсан хаан аль вэ?
a. Цагадай хаан
b. Кебек хаан
c. Төмөр хаан
d. Түклүктөмөр хаан
14. Дараах өгүүлбэрээс зөв хоёр хариултыг сонгоно уу. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
a. Лигдэн хаан Төвдийн улааны шашны лам Ширваа хутагтыг улсын багшаар өргөмжлөв.
b. XVII зууны эхэнд Өвөр Монгол 8 отгоос бүрдэж байв.
c. Хотогойдын Шолой уваш түүхэнд “Алтан хан” хэмээн алдаршжээ.
d. Монголын баруун хойд талд Манж улс хүчирхэгжив.
15. Дараах бичвэрийг нөхөж бичнэ үү. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
Манжийн эрхшээлийн үед аймгийн чуулган жилд удаа чуулна.
16. 1906 онд “Нүүдлийн хэргийг эрхлэх хороо”-г ямар зорилгоор Бээжинд байгуулсан бэ? (1 оноо)
a. Татвар хураах
b. Христийн шашин дэлгэрүүлэх
c. Хятад, манж бичигт сургах
d. Монголд хятад тариачдыг нүүлгэн суулгах
17. VIII Богд Жавзандамба хутагтын намтрын талаар буруу өгүүлсэн зүйл аль вэ? (1 оноо)
a. 1869 онд Төвөдөд төрсөн
b. 1874 онд Халх Монголын бурхны шашны тэргүүнээр тодорсон
c. 1911 оны Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагч
d. 1911-1924 онд Монгол улсын төр, шашныг хослон баригч эзэн хаан
e. 1924 оны 5 сарын 20-нд таалал төгссөн
18. 1914 онд байгуулсан Монгол Улсын Дээд, Доод хурлын үүрэг зорилго юу вэ? (1 оноо)
a. Бүгд найрамдах засаглалд шилжихийн тулд
b. Ноёд, лам нарын зөрчлийг намжаахын тулд
c. Аливаа асуудлыг хэлэлцэж, бодлого боловсруулах, зөвлөх
d. Ноёд, лам, түшмэдийг төрийн албанд тэгш хамруулах
e. Хууль тогтоох байгууллагатай болж, эрх зүйн шинэтгэл хийх
19. Богд хааны Засгийн газрын нэгдсэн Монгол улс байгуулах бодлого ямар баримт бичгээр зогссон бэ? (1 оноо)
a. 1907 оны Орос, Японы Монголын тухай нууц гэрээ бичиг

- b. 1912 оны Орос, Монголын “Найрамдлын гэрээ”
- c. 1913 оны Бээжингийн “Гадаад Монголын автономийн тухай илтгэн гаргах бичиг”
- d. 1915 оны Орос, Хятад, Монгол гурван улсын Хиагтын гэрээ
- e. 1919 оны ДИУ-ын Ерөнхийлөгчийн Гадаад Монголын автономийг цуцалсан зарлиг

20. 1921 оны Монголын хувьсгалыг удирдан зохион байгуулсан улс төрийн хүчин аль вэ? (1 оноо)
- a. Ноёдын нам
 - b. Түшмэдийн нам
 - c. “МАН” гэдэг хувьсгалт байгууллага
 - d. Монгол Ардын Нам

21. Дараах баримт бичгийг уншаад асуултад хариулж бичнэ үү.
 “Хүн ам нь эрүүл чийрэг, боловсрол мэдлэгтэй, тооны хувьд олон бол аль ч улс түргэн хөгжих боломжтой. Иргэд эрүүл чийрэг байхын тулд хүн бүр цэвэр орчинд байж, ариун цэврийг чанд сахих хэрэгтэй...Мөн харьд буй монголчуудаа урьж ирүүлбэл хүн амын тоо олширч, эд хөрөнгө элбэг зузаан болно” (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)
- a. Энэ бодлого зорилтыг ямар баримт бичигт дэвшүүлсэн бэ?
 - b. Уг баримт бичгийг хэдэн онд боловсруулж баталсан бэ?
 - c. Монгол улс энэ баримт бичгийг хэдэн он хүртэл баримталсан бэ?

22. Дараах баримт бичгийг уншаад асуултад хариулж бичнэ үү.
 “Монгол улсыг үүнээс хойш Бүгд найрамдах бүрэн эрхтэй ард улс гэж, улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн улсын аливаа хэргийг УИХ ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүслэн дагавал зохино” (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)
- a. Энэ ямар баримт бичгийн заалт вэ?
 - b. Энэ заалтын үндсэн агуулга юу вэ?
 - c. Уг баримт бичиг хэдээс хэдэн он хүртэл хүчин төгөлдөр байсан бэ?

23. 1945 оны 2 сард Гадаад Монголын статус кво-г хүлээн зөвшөөрсөн улс аль вэ? (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 2 оноо)
- a. Франц
 - b. АНУ
 - c. Польш
 - d. Унгар
 - e. Англи

24. Мэдээллийг уншиж, орхисон үгийг хүснэгтийн тохирох дугаараас нөхөж бичнэ. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)

1974 онд хөдөө нутгийн эгэл жирийн тариачин НТӨ III зуунд холбогдох эртний нэгэн олдворыг олжээ. Археологийн малтлагын үеэр газар доорх урт хонгилд 8000 гаруй дайчдын шавар баримал байгааг илрүүлжээ. Тэд биеийн өндөр, царай төрх, өмссөн хувцсаар хоорондоо ялгаатай. Уг олдворыг(1) гэж нэрлэжээ. Удалгүй тариачин их эзэн хаан (2) бунханыг нээсэн нь тодорхой болжээ. Түүний байгуулсан улс (3) байгууламжаар алдаршсан билээ.

1	2	3
Египетийн тэрэгт цэрэг	Цин Ши хуанди	Галикарнасын бунхан
Агуу арми	Будда Шакьямуни	Родоссын багана
Үхэшгүй мөнхийн цэрэг	Лю Бан	Их цагаан хэрэм
Шавар арми	Ашшурбанал	Карнакийн сүм

25. Дараах бичвэрийг уншиж, 3 даалгавар гүйцэтгэнэ. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)

Уг зэгсний ишинээс хальсыг хуулж, урт, нарийн тууз бэлтгэнэ. Туузыг эгнүүлэн өрөөд сүүл хэсгийг тайрч, нэг ижил хэмжээтэй болгон тэгшилнэ. Дээр нь туузнаас давхарлан ташуу эгнүүлэн өрөөд, тор маягтай болгоно. Ингээд хүнд алхаар давтаж нягтруулаад цавуудна. Цавуудсаны дараа дахин сунгаж татна, ирмэг хэсгийг тайрч, тэгшилнэ. Бэлэн болсон хуудсаа наранд хатаана. Хуудсыг хооронд нь холбон нааж, урт хуйлмал бэлэн болдог.

- I. Бичвэрт юу бэлтгэх эртний аргыг өгүүлсэн бэ? Хариултаас сонгоно.
- a. Торго b. папирус c. Луужин d. Шавар самбар
- II. Түүнийг хаана бэлтгэдэг байсан бэ? Хариултаас сонгоно.
- a. Месопотами b. Хятад c. Египет d. Эртний Энэтхэг
- III. Уг улсын түүхэнд холбогдох байгууламжийг сонгоно.
- a. Сац суварга b. Цагаан хэрэм c. Хиймэл дов d. Зиггурат

26. Дундад зууны Францын түүхэнд холбогдох үйл явдлыг ялгана уу. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)

- a. Верденийн хуваагдал
 b. Схизм
 c. Вандализм
 d. Никагийн бослого
 e. Каролингийн сэргэн мандалт
 f. Англи дахь Нормандын байлдан дагуулал

27. Үйл явдлыг он цагийн зөв дараалалд оруулна уу. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)

- a. Францад “Хүний ба иргэний эрхийн тунхаглал” батлав.
 b. Ватерлоогийн тулалдаан болов.
 c. Симон Боливар Венесуэлийн тусгаар тогтнолыг зарлав.
 d. АНУ тусгаар тогтнолоо зарлав.
 e. Наполеон мэндлэв.
 f. Оросын I Петр хаан өөрийгөө эзэн хаанаар өргөмжлөв.

Хариулт:

1	2	3	4	5	6

28. Зөв дүгнэлтийг ялгана уу. (Зөв хариулт бүр 1 оноо, нийт 3 оноо)

- a. Дэлхийн I дайнд Орос улс Антантын эвсэлд багтаж байв.
 b. Итали Антантын эвсэлд байсан боловч 1915 онд гарч, Гурвын холбоонд нэгдэв.
 c. Дэлхийн I дайны шалтаг болсон үйл явдал Сербийн нутагт болжээ.
 d. Дэлхийн I дайны дараа Австри-Унгарын эзэнт улс задарсан.
 e. Герман Орос улсад дайн зарласнаар дэлхийн I дайн эхлэв.
 f. Дайн дуусахаас өмнө Зөвлөлт Орос улс дайнаас гарсан.